



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**Өсвөр үе залуучуудын хөгжлийн төв, үйлчилгээний
нийтлэг шаардлага**

MNS 7012:2023

Албан хэвлэл

**Стандарт, хэмжил зүйн газар
Улаанбаатар хот
2023 он**

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ БОРЛОСТУУЛАГЧИД ОЙГОВ
СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР, ХТЗ-01/24
МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ МЭН, ХАРИУУЛАГЧИД ОЙГОВ

MNS 7012:2023

Өмнөх үг

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) нь Олон улсын стандартчиллын байгууллагын жинхэнэ гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллагуудтай хамтран үндэсний стандарт боловсруулах ажлыг зохион байгуулдаг.

Үндэсний стандартын төсөл боловсруулах ажлыг салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг бөгөөд Техникийн хороодоор хэлэлцэж дэмжсэн, зөвшилцөлд хүрсэн стандартын төслийг Стандарт, хэмжил зүйн газрын даргын тушаалаар баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн залуучуудын хөгжил, оролцооны бодлого, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Ган-Оюун, Монгол улсын боловсролын их сургуулийн нийгмийн ажлын арга зүйн тэнхимийн багш М.Нямдорж, зөвлөх АУ-ы доктор Ц.Бурмаа нар боловсруулж, СХЗГ-ын мэргэжилтэн Х.Осгонтуяа "MNS 1-2:2022, Монгол улсын стандартчиллын тогтолцоо. 2-р хэсэг: Стандартын бүтэц ба боловсруулах дүрэм" стандартад нийцүүлсэн.

Уг стандартыг Хүүхдийн хөгжил, хамгааллын техникийн хорооны хурлаар хэлэлцэж дэмжсэн болно.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Улаанбаатар 13343, Ш/Х - 48

Утас: 263860, 262201

Факс (976-11) 458032

E-mail: standardinform@masm.gov.mn,

www.masm.gov.mn, www.estandard.gov.mn

© СХЗГ 2023

"Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай" хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-д байна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 03.080.30

Өсвөр үе залуучуудын хөгжлийн төв. Үйлчилгээний нийтлэг шаардлага	MNS 7012:2023
Youth development center, general requirement of service	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 28 дугаар тушаалаар батлав.

Энэхүү стандарт нь 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс хүчинтэй.

1 Зорилго

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй (өмчийн бүх хэлбэрийн) өсвөр үе залуучуудын хөгжлийн төвийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагыг тогтоож, мөрдүүлэхэд оршино.

2 Хамрах ба хэрэглэх хүрээ

Монгол Улсын нутаг дэвсгэр дэх залуучуудад үйлчилгээ үзүүлж буй өсвөр үе, залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагаанд хамаарна.

3 Норматив эшлэл

Энэ стандартын үзэл санаа нь Олон улсын болон Монгол Улсын хэмжээнд баримталж буй дараах бодлогын баримт бичгүүдэд суурилсан бөгөөд эдгээрийг нэгэн адил дагаж мөрдөнө. Үүнд:

MNS 5852:2017, *Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага*;
MNS 6620:2016, *Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавих шаардлага*;

MNS 6417:2013, *Гэр бүлийн зөвлөгөө өгөх төвд тавих нийтлэг шаардлага*;

MNS 5936:2008, *Харилцан нөлөөлөх бүлгийн сэтгэл засал*;

MNS 4990:2015, *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага*;

MNS 6949:2021, *Нийгмийн ажлын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага*;

MNS 5538:2005, *Чийрэгжүүлэх, бялдаржуулах үйлчилгээ. Нийтлэг шаардлага*;

MNS 6040:2019, *Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага*;

MNS 6418:2013, *Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих шаардлага*;

MNS 6419:2021, *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засалт, хөгжлийн төвийн бүтэц, үйл ажиллагаа, үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага*;

MNS 6912:2021, *Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Эвент танхимын үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага*;

MNS 6913:2021, *Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Видео студид тавих ерөнхий шаардлага*;

MNS 6914:2021, *Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Дуу бичлэгийн студид тавих ерөнхий шаардлага*;

MNS 6752:2019, *Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ*;

MNS 5742:2019, *Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага*.

MNS 7012:2023

4 Нэр томьёо, тодорхойлолт

Энэхүү нийтлэг шаардлагад хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

4.1

залуучууд

15-34 насны залуучууд, үүнд 15-18 насны хүүхэд, өсвөр үеийнхэн, 19-34 насны залуучууд

4.2

зсрилтот бүлгийн хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучууд

зсрилтот бүлгийн залуучууд, үүнд: хэвийн ажиллах амьдрахад нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн (ХБХЭТ хууль, 4.1.1), "ажил олоход хүндрэлтэй иргэн" (ХЭДТ хууль, 3.1.7) залуучууд

4.3

залуучуудын хөгжил

залуучуудад тулгарах асуудал, бэрхшээлийг даван туулах чадамж, залуучуудын бие бялдар, оюун санаа, сэтгэлгээ, ур чадвар, харилцаанд гарч байгаа ахиц өөрчлөлт

4.4

үйлчлүүлэгч

төвийн үйлчилгээнд хамрагдаж буй 15-34 насны хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучууд

4.5

залуучуудын оролцоо

залуучуудын улс төр, эдийн засаг, нийгмийн хөгжил, шийдвэр гаргах түвшинд үзэл бодлоо илэрхийлэх, оролцох үйл явц

4.6

хөгжлийн үйлчилгээ

ахиц өөрчлөлтийг бий болгоход чиглэсэн арга хэмжээ, үйлчилгээ

4.7

залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээ

залуучуудын хөгжлийг дэмжихэд чиглэсэн урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх болон бусад арга хэмжээ, үйлчилгээ;

4.8

хөгжлийн төлөвлөгөө

ахиц өөрчлөлтийг бий болгох арга хэмжээ, үйлчилгээний төлөвлөлтийг буюу хувь хүний хөгжлийн эрэлт, хэрэгцээ, дутагдалтай ур чадвар, чадавхыг ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага, уулзалтын үеэр үнэлэн тодорхойлж, үнэлгээнд үндэслэн хамтран боловсруулсан сургалт, хөгжлийн төлөвлөгөө

4.9

амьдрах ухааны сургалт

гэр бүл төлөвлөлт, санхүүгийн мэдлэг болон эрүүл, аюулгүй ажиллах, амьдрах дадал, төлөвшил, нийгэм сэтгэл зүйн чадварыг олгох сургалт-ыг цахимаар болон танхимаар зохион байгуулах үйл ажиллагаа

4.10**сонирхлын клуб, зөвлөл**

залуучуудын хүсэл, сонирхол, эрэлт, хэрэгцээнд тулгуурласан, оролцоог дэмжсэн сонирхлын клуб, зөвлөл, бүлгийн үйл ажиллагаа

4.11**хууль зүйн анхан шатны туслалцаа**

Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулиар хамгаалагдсан эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн, хохирсон 15-34 насны залуучуудад хууль зүйн туслалцаа авах, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээнд холбон зуучлах болон зөвлөгөө, зөвлөмж өгөх

4.12**эрүүл мэндийн анхан шатны зөвлөгөө, нөлөөллийн ажил**

залуучуудад хорт зуршлаас ангид байх, эрүүл амьдралын хэв маяг, зөв дадал, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн байгууллагатай хамтран урьдчилан сэргийлэх нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах, мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээнд холбон зуучлах

4.13**залуучуудад гэр бүлийн зөвлөгөө өгөх**

залуучуудад гэр бүлийн боловсрол олгох, залуу гэр бүл тулгамдсан бэрхшээлээ хамтдаа даван туулахад туслах, чиглүүлэх мэргэжлийн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, холбон зуучлах

4.14**сэтгэл зүйн зөвлөгөө**

залуучуудад сэтгэл зүйн хувьд тулгамдаж буй сэтгэл гутрал, стресс, түгшүүр, донтолт, өөртөө итгэлгүй байдал, харилцааны болон сэтгэл зүйн бусад асуудал, бэрхшээлээ ойлгох, сэргийлэх, даван туулахад туслах мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ

4.15**ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө, арга хэмжээ**

хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал, эрэлттэй ажил мэргэжлийн талаар зөвлөн мэдээлэх ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөөг дангаар болон холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран хүргэх, хөдөлмөр эрхлэх ур чадвар, чадавхын хэрэгцээг үнэлэн тодорхойлох, холбон зуучлах, мэргэшсэн зөвлөх үйлчилгээ

4.16**хөдөлмөр эрхлэлтийг дэмжих анхан шатны зөвлөгөө, үйлчилгээ**

гарааны бизнес эрхлэх болон бусад холбогдох чадавх бэхжүүлэх хөтөлбөр, сургалт, арга хэмжээнд холбон зуучлах, оюутны цагаар хөдөлмөр эрхлэхийг дэмжиж түр болон байнгын ажлын байранд холбон зуучлах, оффисын байраар хангахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн байгууллагатай хамтран үзүүлэх үйл ажиллагаа

4.17**сайн дурын ажил**

сайн дурын ажилтныг бэлтгэх, бүртгэх, сайн дурын ажлыг зохион байгуулах, сурталчлан таниулах үйл ажиллагаа

MNS 7012:2023

4.18

оролцоог дэмжих үйлчилгээ

шийдвэр гаргах үйл явцад залуучуудын оролцоог дэмжих, хүмүүнлэгийн ба сайн дурын үйл ажиллагааг дэмжих үйлчилгээ

4.19

залуу гэр бүлийг дэмжих хөгжлийн үйлчилгээ

залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан гэр бүлийн болон санхүүгийн боловсрол олгох модуль сургалтад хамрагдсан хуримаа хийж амжаагүй залуу гэр бүлийн хуримын үйл ажиллагааг иргэний бүртгэлийн болон бусад мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах сургалт, ёслолын үйл ажиллагаа

4.20

дэмжих бүлэг

ижил тулгамдсан асуудалтай хүмүүс хамтран асуудлаа шийдвэрлэх арга замаа тодорхойлох, туршлага солилцох, харилцан бие биедээ туслах үйл ажиллагаа бүхий өөртөө туслах бүлгийн үйл ажиллагаа; (өөртөө туслах бүлгийн үйлчилгээг уулзалт, чөлөөт ярилцлага хэлбэрээр зохион байгуулна).

5 Өсвөр үе, залуучуудын хөгжлийн төвд тавих ерөнхий шаардлага

5.1 Төв нь аймаг, нийслэл, дүүрэг, сум, хороонд үйл ажиллагаагаа явуулж, залуучуудын хөгжил оролцооны чиглэлээр бодлого хэрэгжилтийг ханган ажиллана.

5.2 Салбар дундын хамтын ажиллагаа хөгжүүлэх, олон салбарын байгууллагын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах орчныг бүрдүүлнэ.

5.3 Төв нь үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий байр, ажлын өрөө, ганцаарчилсан, бүлгийн болон залуу хосуудад зөвлөгөө өгөх, нийгэм-сэтгэлзүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх өрөөтэй байна.

5.4 Төв нь залуучуудад чиглэсэн үйлчилгээ үзүүлэх, үйл ажиллагааг тогтвортой явуулна.

5.5 Төв нь өөрийн үйлчилгээний ёс зүйн дүрэмтэй, ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллана.

5.6 Төв нь залуучуудтай ажиллах үйлчилгээний онол, арга зүйн хөтөлбөртэй байна.

5.7 Төв нь үйлчилгээ үзүүлэх хүний нөөц, санхүүгийн болон тоног төхөөрөмж, техник технологийн нөөцтэй байна.

5.8 Мэргэжилтэн, ажилтнуудын мэргэжлийн боловсрол, мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, практик туршлагыг нэмэгдүүлэх тогтвор суурьшилтай ажиллах боломжоор хангахад чиглэгдсэн хүний нөөцийн төлөвлөгөөтэй байна.

5.9 Үйлчлүүлэгчийн бүртгэлийг хөтөлж мэдээллийн нууцыг хадгална.

5.10 Үйлчилгээний баримт бичгийг архивлан хадгална.

6 Өсвөр үе, залуучуудын хөгжлийн төвийн ажилтанд (мэргэжилтэнд) тавих шаардлага

6.1 Төвийн мэргэжилтэн нь магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийг төгссөн, нийгмийн ажил, хүмүүнлэгийн ухааны бакалавр буюу түүнээс дээш боловсролын зэрэгтэй байна.

6.2 Мэргэжилтэн нь хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучуудын хөгжлийг дэмжихтэй холбогдсон дараах мэдлэг, ур чадвартай байна. Үүнд:

- нийгмийн ажил, хүмүүнлэгийн шинжлэх ухааны онол, үзэл баримтлал, хүний хөгжлийн болон хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучуудын хөгжил, онцлог, ялгаатай байдлын талаар,
- холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын талаар мэдлэгтэй, түүнийг хэрэгжүүлэх,
- хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучуудын давуу талыг тодорхойлох, чадавхыг дэмжих арга хэмжээ, үйлчилгээг хувь хүн, гэр бүл, бүлэг (клуб), байгууллага, олон нийтэд зохион байгуулах,
- нийгмийн судалгааны аргуудыг ашиглах, судалгаа, дүн шинжилгээ хийх, тайлагнах, үр дүнд суурилсан үйл ажиллагаа явуулах,
- хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучуудыг урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, нөлөөллийн; соёл урлаг, шинжлэх ухаан, спортын арга хэмжээг зохион байгуулах, оролцоог дэмжих, холбон зуучлах,
- салбар дундын хамтын ажиллагаанд тулгуурлан хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах,
- сайн дурын ажилтныг бүртгэх, чадавхжуулах, сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулах,
- үйлчлүүлэгчийн хувийн болон байгууллагын үйлчилгээний нууцыг хадгалах, ёс зүйн хэм хэмжээг сахих. (Шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгчтэй нууцын гэрээ байгуулж болно.)

7 Үйлчилгээний төрөл, хэлбэр

Дараах төрлийн үйлчилгээг цахимаар, танхимаар, ганцаарчилсан болон бүлгээр зохион байгуулна.

7.1 Зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ

- 7.1.1** Хувь хүний хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх дэмжлэг,
- 7.1.2** Ажил мэргэжлийн чиг баримжаа, хөдөлмөр эрхлэлтийн зөвлөгөө,
- 7.1.3** Нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүлийн зөвлөгөө,
- 7.1.4** Сэтгэл зүйн зөвлөгөө,
- 7.1.5** Хууль эрх зүйн зөвлөгөө.

7.2 Холбон зуучлах үйлчилгээ

- 7.2.1** Эрүүл мэндийн зөвлөгөө, үйлчилгээ,
- 7.2.2** Сэтгэл зүйн болон сэтгэл заслын зөвлөгөө, үйлчилгээ,
- 7.2.3** Хууль эрх зүйн тусламж зөвлөгөө, үйлчилгээ,
- 7.2.4** Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөгөө, үйлчилгээ,
- 7.2.5** Гэр бүлийн зөвлөгөө, дэмжих үйлчилгээ,
- 7.2.6** Сайн дурын ажил.

7.3 Сургалт зохион байгуулах, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах

- 7.3.1** Амьдрах ухааны чадвар олгох сургалт,
- 7.3.2** Гэр бүлийн харилцаа, гэр бүл төлөвлөлтийн сургалт,

MNS 7012:2023

7.3.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт (мэргэжлийн байгууллагатай хамтарч болно),

7.3.4 Сайн дурын ажилтан бэлтгэх сургалт, сайн дурын үйл ажиллагаа,

7.3.5 Залуучууд сонирхлын дагуу нэгдэхийг дэмжих, сонирхлын клуб, зөвлөл, бүлгийг зохион байгуулалтаар дэмжих.

ТӨГСӨВ.

А хавсралт
(норматив)

Өсвөр үе, залуучуудын хөгжлийн төвд тавих норматив шаардлага

№	Шаардлага	Норм	
1	Төвийн дотоод орчин, өрөө, тоног, төхөөрөмж	Төвийн хаягийг монгол хэл (кирилл болон үндэсний бичиг)-ээр бичсэн, харагдахуйц газар байрлуулсан	+
		Жилийн ажлын төлөвлөгөө, тайлан, үйл ажиллагааг сурталчилсан мэдээллийн самбар	+
		Сэтгэл ханамжийн судалгаа, санал хүсэлт хүлээн авах хайрцаг	+
		Төлөвлөлтийн самбар	
		Ганцаарчилсан уулзалт, ярилцлага хийх өрөө	+
		Ажилтны ажлын өрөө	+
		Сургалт, сурталчилгаа хийх танхим	+
		Ширээ, сандал,	
		Зөөлөн сандал, сэтгүүлийн ширээ,	+
		Халуун/хүйтэн усны аппарат	+
		Суурин компьютер	+
		Хэвлэгч, сканер, хувилагч	+
		Нөүтбүүк	+
		Проектор	+
		Видео камер	+
Номын сан	+		
2	Хүний нөөц	Өсвөр үе, залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн ажлын албаны нарийн бичгийн дарга	+
		Сургалт хариуцсан ажилтан	+
		Оролцоо, хамтын ажиллагаа хариуцсан ажилтан	+

Ном зүй

Нэгдсэн үндэсний байгууллага (НҮБ)-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ),
Нэгдсэн Үндэсний Байгууллага (НҮБ) Хүүхдийн эрхийн тухай Конвенц,
Залуучуудын хөгжлийн Төвийн үлгэрчилсэн дүрэм
Үндэсний хөтөлбөр

- Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр
- Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр
- Залуучуудын мэдээллийн сан бүрдүүлэх хөтөлбөр
- Хорих ял эдэлж байгаа болон суллагдсан өсвөр үе, залуучуудыг нийгэмшүүлэх дэд хөтөлбөр
- Залуучуудын сайн дурын ажлыг бүртгэх баталгаажуулах журам
- Залуучуудын хөгжлийн үндэсний болон Салбар зөвлөлийн дүрэм
- Залуучуудын статистикийн нэгдсэн үзүүлэлт түүнийг тооцох аргачлал
- Залуучуудын мэдээллийн сан бүрдүүлэх журам
- Асрамж халамжийн төвүүдийн залуучуудын “Бие даан амьдрах” чадварыг хөгжүүлэх жишиг хөтөлбөр